



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/180/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаангом сум 2026 он	Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Аудитор: Т.Ариунсайхан Утас: 70453799, Цахим хаяг: Ariunsaikhant@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Үндсэн/	11
2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Нэмэлт/.....	13
2.7 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Ахмадын сан/	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.5.1 Төсвийн төлөвлөлт	16
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	16
3.5.3 Нэмэлт төсөв.....	17
3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн	17
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл.....	17
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
4.5.1 Завсрын аудитын талаар	19
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	21

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

УВС АЙМГИЙН УС ЦАГ УУР ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ДАРГА
Б.ПҮРЭВСҮРЭН ТАНАА

2026.02.11 № УВА-2026/180/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Увс аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Увс аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050688

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>253,651,415.59</u>	<u>238,754,946.76</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	900,000.00	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	900,000.00	-
3121	Төгрөг	900,000.00	-
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	900,000.00	-
33	АВЛАГА	-	7,823,881.89
335	Бусад авлага	-	7,823,881.89
3351	Байгууллагаас авах авлага	-	7,285,081.89
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	538,800.00
35	БАРАА МАТЕРИАЛ	252,751,415.59	230,931,064.87
351	Түүхий эд материал	200,732,855.89	181,294,940.57
35110	Тусгай зориулалттай материал	200,732,855.89	181,294,940.57
354	Хангамжийн материал	52,018,559.70	49,636,124.30
35420	Аж ахуйн материал	40,047,209.70	38,381,027.70
35430	Сэлбэг хэрэгсэл	1,971,350.00	1,255,096.60
35450	Барилгын засварын материал	10,000,000.00	10,000,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,623,538,625.87</u>	<u>2,548,352,324.63</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,623,538,625.87	2,548,352,324.63
392	Биет хөрөнгө	2,095,637,000.87	2,020,638,199.63
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,853,074,057.00	1,853,074,057.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(207,640,336.73)	(246,765,268.01)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	78,957,573.78	86,686,606.04
39204	Хуримтлагдсан элэгдэл	(36,962,307.26)	(45,342,064.70)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	639,044,677.46	551,253,908.04
39206	Хуримтлагдсан элэгдэл	(236,952,945.94)	(186,392,951.46)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,426,984.05	21,062,234.05
39208	Хуримтлагдсан элэгдэл	(15,506,701.49)	(16,134,321.33)
39217	Ном	3,196,000.00	3,196,000.00
393	Биет бус хөрөнгө	527,901,625.00	527,714,125.00
39301	Программ хангамж	3,400,000.00	3,400,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,994,375.00)	(2,181,875.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	526,496,000.00	526,496,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,877,190,041.46</u>	<u>2,787,107,271.39</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>6,717,226.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	6,717,226.00
413	Өглөг	-	6,717,226.00
4136	Бусад өглөг	-	6,717,226.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	6,717,226.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,877,190,041.46</u>	<u>2,780,390,045.39</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,877,190,041.46	2,780,390,045.39
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,016,818,934.41	1,016,818,934.41

51101	Өмч: - төрийн	1,016,818,934.41	1,016,818,934.41
512	Хуримтлагдсан үр дүн	1,826,861,886.05	1,730,061,889.98
51210	Өмнөх үеийн үр дүн	1,316,066,510.11	1,826,861,886.05
51220	Тайлант үеийн үр дүн	510,795,375.94	(96,799,996.07)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	33,509,221.00	33,509,221.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,877,190,041.46</u>	<u>2,787,107,271.39</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,470,742,008.71	4,053,498,042.24
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	651,984,238.71	235,795,697.24
120	Нийтлэг татварын бус орлого	651,984,238.71	235,795,697.24
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	651,984,238.71	235,795,697.24
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	210,500.00	9,440,400.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	651,773,738.71	226,355,297.24
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,818,757,770.00	3,817,702,345.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,742,508,400.00	3,814,072,845.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,742,508,400.00	3,814,072,845.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	76,249,370.00	3,629,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,500,000.00	3,379,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	53,460,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,289,370.00	250,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,959,946,632.77	4,150,298,038.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,959,946,632.77	4,150,298,038.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,790,726,542.61	3,921,207,417.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,991,481,869.83	3,070,927,086.62
210101	Үндсэн цалин	1,706,188,469.83	1,732,246,941.62
210102	Нэмэгдэл	849,828,120.00	932,035,055.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	258,292,500.00	207,310,000.00
210104	Урамшуулал	177,172,780.00	199,335,090.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	372,995,104.21	381,058,612.38
210201	Тэтгэврийн даатгал	257,323,676.42	262,581,301.70
210202	Тэтгэмжийн даатгал	30,173,460.48	30,875,769.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,516,241.04	15,863,965.36
210204	Ажилгүйдлийн даатгал	13,993,962.97	14,338,344.33
210205	Эрүүл мэндийн даатгал	55,987,763.30	57,399,231.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,023,704.20	94,527,738.11
210301	Гэрэл, цахилгаан	14,099,900.00	20,425,199.21
210302	Түлш, халаалт	52,125,913.20	69,476,738.90
210303	Цэвэр, бохир ус	3,797,891.00	4,625,800.00

2104	Хангамж, бараа материалын зардал	19,409,549.60	19,528,225.00
210401	Бичиг хэрэг	2,190,450.00	304,700.00
210402	Тээвэр, шатахуун	8,994,840.00	9,819,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,035,999.60	5,037,000.00
210404	Ном, хэвлэл		879,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		363,017.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,188,260.00	3,124,808.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,439,550.00	10,296,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		850,400.00
210604	Урсгал засвар	4,439,550.00	9,445,700.00
2107	Томилолт, зочны зардал	7,658,000.00	5,993,800.00
210702	Дотоод албан томилолт	7,658,000.00	5,993,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	48,308,382.00	12,574,988.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,297,700.00	6,177,424.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	1,657,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	267,950.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	81,180.00	92,180.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	
210807	Газрын төлбөр	4,012,752.00	4,648,184.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	276,410,382.77	326,300,867.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	144,048,285.48	199,729,083.71
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	448,000.00	3,471,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	131,914,097.29	123,100,583.49
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	169,220,090.16	229,090,621.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	131,639,220.20	225,610,233.48
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	53,460,000.00	5,293,000.00
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	328,000.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	77,451,220.20	219,617,233.48
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	700,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	37,580,869.96	3,480,387.52
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	37,580,869.96	3,480,387.52
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>510,795,375.94</u>	<u>(96,799,996.07)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>510,795,375.94</u>	<u>(96,799,996.07)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>3,819,868,270.00</u>	<u>3,827,142,745.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,110,500.00	9,440,400.00

120	Нийтлэг татварын бус орлого	1,110,500.00	9,440,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,110,500.00	9,440,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,110,500.00	9,440,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,818,757,770.00	3,817,702,345.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,742,508,400.00	3,814,072,845.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,742,508,400.00	3,814,072,845.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	76,249,370.00	3,629,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,500,000.00	3,379,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	53,460,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,289,370.00	250,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,698,975,770.00	3,825,207,495.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,698,975,770.00	3,825,207,495.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,528,855,679.84	3,589,432,277.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,989,711,084.04	3,079,206,784.00
210101	Үндсэн цалин	1,346,660,900.00	1,407,594,600.00
210102	Нэмэгдэл	1,142,356,984.04	1,163,844,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	341,858,900.00	273,174,000.00
210104	Урамшуулал	158,834,300.00	234,593,784.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгал төлөх шимтгэл	374,765,890.00	374,118,200.00
210201	Тэтгэврийн даатгал	253,881,390.00	256,156,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	30,221,100.00	29,958,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,110,500.00	15,073,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	15,110,600.00	14,585,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	60,442,300.00	58,343,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,023,704.20	94,527,738.11
210301	Гэрэл, цахилгаан	14,099,900.00	20,425,199.21
210302	Түлш, халаалт	52,125,913.20	69,476,738.90
210303	Цэвэр, бохир ус	3,797,891.00	4,625,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,067,249.60	10,187,517.00
210401	Бичиг хэрэг	1,525,010.00	345,400.00
210402	Тээвэр, шатахуун	8,994,840.00	3,101,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,035,999.60	4,359,000.00
210404	Ном, хэвлэл	-	879,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	363,017.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,511,400.00	1,138,600.00
2105	Нормативт зардал	1,032,770.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	738,770.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	294,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,335,300.00	8,914,750.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	132,000.00	850,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,115,000.00	-
210604	Урсгал засвар	6,088,300.00	8,064,350.00

2107	Томилолт, зочны зардал	7,658,000.00	5,993,800.00
210702	Дотоод албан томиллолт	7,658,000.00	5,993,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52,211,382.00	13,252,988.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	47,057,700.00	6,855,424.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	1,657,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	267,950.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	81,180.00	92,180.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	143,000.00	-
210807	Газрын төлбөр	4,012,752.00	4,648,184.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,050,300.00	3,230,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,560,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	490,300.00	3,230,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	170,120,090.16	235,775,217.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	132,539,220.20	225,810,233.48
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	53,460,000.00	5,293,000.00
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	328,000.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	77,451,220.20	219,617,233.48
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,300,000.00	900,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	37,580,869.96	9,964,984.41
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	37,580,869.96	9,964,984.41
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>120,892,500.00</u>	<u>1,935,250.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	119,992,500.00	2,835,250.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	119,992,500.00	2,835,250.00
2200	Дотоод эх үүсвэрээр	119,992,500.00	2,835,250.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	119,992,500.00	2,835,250.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(119,992,500.00)</u>	<u>(2,835,250.00)</u>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	900,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	900,000.00	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,016,818,934.41	19,577,221.00	1,316,066,510.11	00.00	2,352,462,665.52
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00

C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,016,818,934.41	19,577,221.00	1,316,066,510.11	0.00	2,352,462,665.52
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	13,932,000.00	0.00	00.00	13,932,000.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	510,795,375.94	00.00	510,795,375.94
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,016,818,934.41	33,509,221.00	1,826,861,886.05	0.00	2,877,190,041.46
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,016,818,934.41	33,509,221.00	1,826,861,886.05	0.00	2,877,190,041.46
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,016,818,934.41	33,509,221.00	1,826,861,886.05	0.00	2,877,190,041.46
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-96,799,996.07		-96,799,996.07
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,016,818,934.41	33,509,221.00	1,730,061,889.98	0.00	2,780,390,045.39

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Үндсэн/

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,855,130,400.00	3,813,548,260.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,855,130,400.00	3,813,548,260.59

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,595,220,600.00	3,588,838,027.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,079,774,300.00	3,079,206,784.00
210101	Үндсэн цалин	1,407,594,600.00	1,407,594,600.00
210102	Нэмэгдэл	1,163,844,400.00	1,163,844,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	273,174,000.00	273,174,000.00
210104	Урамшуулал	235,161,300.00	234,593,784.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	374,118,200.00	374,118,200.00
210201	Тэтгэврийн даатгал	256,156,500.00	256,156,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	29,958,300.00	29,958,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,073,800.00	15,073,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	14,585,800.00	14,585,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	58,343,800.00	58,343,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	94,528,200.00	94,527,738.11
210301	Гэрэл, цахилгаан	20,425,200.00	20,425,199.21
210302	Түлш, халаалт	69,477,200.00	69,476,738.90
210303	Цэвэр, бохир ус	4,625,800.00	4,625,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,089,800.00	8,758,017.00
210401	Бичиг хэрэг	486,900.00	295,400.00
210402	Тээвэр, шатахуун	3,101,900.00	3,101,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,622,100.00	2,979,500.00
210404	Ном, хэвлэл		879,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	445,700.00	363,017.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,433,200.00	1,138,600.00
2105	Нормативт зардал	3,859,800.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,859,800.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,898,800.00	10,894,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	850,400.00	850,400.00
210602	Тавилга	2,400,000.00	2,395,250.00
210604	Урсгал засвар	7,648,400.00	7,648,350.00
2107	Томилолт, зочны зардал	6,000,000.00	5,993,800.00
210702	Дотоод албан томилолт	6,000,000.00	5,993,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,721,000.00	12,108,988.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,095,000.00	5,711,424.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,697,400.00	1,657,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	138,900.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	92,200.00	92,180.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	49,300.00	-
210807	Газрын төлбөр	4,648,200.00	4,648,184.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,230,500.00	3,230,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,230,500.00	3,230,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	259,909,800.00	224,710,233.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	259,909,800.00	224,710,233.48
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	38,768,000.00	5,093,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	221,141,800.00	219,617,233.48

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,855,130,400.00	3,813,548,260.59
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,854,930,400.00	3,810,592,457.48
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,854,930,400.00	3,810,592,457.48
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	200,000.00	2,955,803.11
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,000.00	2,955,803.11

2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Нэмэлт/

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,629,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,629,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,429,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,869,500.00
210401	Бичиг хэрэг	50,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,379,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	440,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	416,000.00
210604	Урсгал засвар	416,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,144,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,144,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	200,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	200,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,629,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,629,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,379,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	250,000.00

2.7 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Ахмадын сан/

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	900,000.00
	Нийт зардал ба тусламжийн дүн	900,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	900,000.00
	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Увс аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв нь ус цаг уур, байгаль орчны мэдээллээр нийгмийн хэрэгцээг шуурхай хангах, байгалийн гамшиг орчны ноцтой бохирдлоос сэрэмжлүүлэхэд оршино.

Ус цаг уур, орчны төлөв байдлын өөрчлөлтийн мэдээ, мэдээллээр нийгмийн хэрэгцээг хангаж, байгаль цаг агаарын болзошгүй аюул гамшиг, орчны ноцтой бохирдлоос сэрэмжлүүлэх, ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний нэгжүүдийг арга зүй технологийн удирдлагаар хангаж, тэдний тасралтгүй хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, хяналт шинжилгээнд ашиглаж буй хэмжих хэрэгсэл, багаж төхөөрөмжийн үзлэг үйлчилгээ, шалгалт тохируулгыг тогтмол хийж хэмжлийн байдлыг хангах байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Увс аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах нэмэлт, өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон;
- Төрийн албаны тухай хуульд – 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр;
- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- Төсвийн тухай хуульд - 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр, 07 дугаар сарын 09-ний өдөр.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна. Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн байна.

Увс аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв нь санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн "Unicus" программ ашиглан бэлтгэж, Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/163 дугаар тушаалаар батлуулсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг жишиг болгон мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 90,082.8 мянган төгрөгөөр буюу 3.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	900.00	-	(900.00)
Авлага	-	7,823.88	7,823.88
Бараа материал	252,751.42	230,931.06	(21,820.36)
Үндсэн хөрөнгө	2,623,538.63	2,548,352.32	(75,186.31)
Нийт хөрөнгө	2,877,190.04	2,787,107.27	(90,082.77)
Өр төлбөр	-	6,717.23	6,717.23
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,877,190.04	2,780,390.04	(96,800.00)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,877,190.04	2,787,107.27	(90,082.77)

Мөнгөн хөрөнгийн данс тайлант оны эхэнд 900.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол тайлант оны эцэст үлдэгдэлгүй байна.

Авлага данс оны эхэнд үлдэгдэлгүй, эцэст 7,823.88 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь байгаль орчны шинжилгээний лабораторийн давсан орлого, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага, ажилчдаас авах авлагууд байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 230,931.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 21,820.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,548,352.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 75,186.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 125,340.8 мянган төгрөгийн хөрөнгө акталан нь гол нөлөө үзүүлжээ.

Тайлант онд 6,717.2 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байгаа нь төсөвт тусгагдсан санхүүжилт олгоогүй нь улмаас үүссэн бензиний өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,780,390.0 мянган төгрөг болж, 96,800.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,490,006.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс улсын төсвийн санхүүжилтийг 503,967.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 3,993,973.5 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 138,843.1 мянган төгрөгөөр бууруулан 3,855,130.4 мянган төгрөг болгон тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр баталсан байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,813,548.3 мянган төгрөг буюу 98.9 хувийг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал /80101/	3,590,270.60	3,585,271.60	4,999.00	99.86%
2	Холбооны суваг ашигласны төлбөр /80220/	4,950.00	3,566.42	1,383.58	72.05%
3	Ажил олгогчоос олгох тэтгэмж /80802/	259,909.80	224,710.23	35,199.57	86.46%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

/мянган төгрөг/

Д/д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тайлбар
1	Программ хангамжийн бүртгэл	-	-	Нягтлан бодох бүртгэлийн "Unicus" программыг ашиглаж байна.
2	Унаа, хоолны зарцуулалт	273,174.0	273,174.0	Ус цаг уур орчны шинжилгээний төв нь тайлант хугацаанд албан хаагчдын хоолны хөнгөлөлтөд 3 удаа өөрчлөлт оруулсан байна. Үүнд: -2025.06.18 А/27 тушаалаар (аймгийн төв 10.0 мянган төгрөг, сум 7.5 мянган төгрөг) -2025.08.01 А/40 тушаалаар (аймгийн төв 10.0 мянган төгрөг, сум 5.0 мянган төгрөг); -2025.12.18 А/60 тушаалаар (аймгийн төв 30.0 мянган төгрөг, сум 12.5 мянган төгрөг); Тайлант онд 273,174.0 мянган төгрөгийн хоолны зардал олгосон байна.

3	Сургалт, семинар, хурал зөвлөгөөний зардал	3,230.5	3,230.5	УЦУОШТ-ийн албан хаагчдыг мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангах, чадавхжуулах сургалт, Өмнеговь суманд Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, ард иргэдэд мэргэжлээ сурталчлан таниулах арга хэмжээг тус тус зохион байгуулсан.
4	Гадаад томилолт, арга хэмжээ	-	-	Зардал гараагүй.
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	-	-	Зардал гараагүй.
6	Орон тоо	3,079,774.3	3,079,206.8	Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2025 оны 08 дугаар сарын А/162 дугаар тушаалаар "Аймаг, хотын Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дүрэм, бүтэц, орон тооны хязгаар"-ыг баталсан байна. Бүтэц, орон тооны хязгаар шинэчлэн батлагдсантай холбоотойгоор 14 албан хаагч орон тооны цомхотголд орж, тайлант онд 81 үндсэн ажилтан, 4 гэрээт ажилтантайгаар үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна.
7	Хэвлэл мэдээлэл	-	-	Зардал гараагүй.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 250.0 мянган төгрөг, ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ашиглагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 3,379.5 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авснаас шуудан холбоо, интернэтийн төлбөрт 1,379.5 мянган төгрөг, бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 1,144.0 мянган төгрөг, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсэд 440.0 мянган төгрөг, урсгал засварт 416.0 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 50.0 мянган төгрөг, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулалд 200.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Увс аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвд тайлант онд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр байхгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Увс аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв нь тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй бөгөөд 2,835.3 мянган төгрөгийн тавилга, эд хогшил худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Ариунсайхан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт Увс аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2026 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 14 дүгээр албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,959,946.6 мянган төгрөгийн 1 хувиар буюу 39,599.5 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 31,679.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,150,298.0 мянган төгрөгийн 1 хувиар буюу 41,503.0 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 33,202.4 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Увс аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Увс аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв нь тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс хугацаандаа оруулсан 168, хугацаа хоцроосон 1, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

Бусад хууль тогтоомжийн хүрээнд горим сорил хэрэгжүүлэхэд дараах асуудал илэрлээ. Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2025 оны 08 сарын 04-ний өдрийн А/162 дугаар тушаалаар "Аймаг, хотын Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дүрэм, бүтэц, орон тооны хязгаар"-ыг баталсан. Бүтэц, орон тооны өөрчлөлттэй холбоотойгоор 14 албан хаагчийг цомхотгосон байна. Тайлант онд 4 албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарсан бөгөөд хөдөлмөр эрхлэлтийн харилцаагаа цуцалсан 4 албан хаагчийг эгүүлэн авсан. Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болсон 10 албан хаагчид хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсны тэтгэмж олгох тушаал гарсан ч санхүүжилтгүй нь улмаас нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 3 албан хаагчийн тэтгэмжийг олгосон байна. Хөдөлмөрийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 дүгээр хэсэгт "Энэ хуулийн 65.4.2, 80.1.1, 80.1.2, 80.1.3-т заасан үндэслэлээр хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсан ажилтанд нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмж авах эрхтэй эсэхээс үл хамааран ажил олгогч дараах хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно", 82.1.1 дүгээр заалтад "тухайн аж ахуйн нэгж, байгууллагад зургаан сараас хоёр жил хүртэл ажилласан бол нэг ба түүнээс дээш сарын үндсэн цалинтай тэнцэх", 82.1.2 дугаар заалтад "тухайн аж ахуйн нэгж, байгууллагад хоёр жилээс тав хүртэл жил ажилласан бол хоёр ба түүнээс дээш сарын үндсэн цалинтай тэнцэх", 82.1.3 дугаар заалтад "тухайн аж ахуйн нэгж, байгууллагад таван жилээс 10 хүртэл жил ажилласан бол гурав ба түүнээс дээш сарын үндсэн цалинтай тэнцэх", 82.1.4 дүгээр заалтад "тухайн аж ахуйн нэгж, байгууллагад 10 ба түүнээс дээш жил ажилласан бол дөрөв ба түүнээс дээш сарын үндсэн цалинтай тэнцэх" гэж заасны дагуу 7 албан хаагчийн 28,287.0 мянган төгрөгийн хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсны тэтгэмжийг нөхөж олгохыг анхаарч ажиллахыг зөвлөж байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Увс аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолын 10, 11 дүгээр хавсралтаар төрийн үйлчилгээний албан хаагчдын албан тушаалын цалингийн

доод хэмжээг заасан байдаг. Увс аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв нь Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн Төрийн үйлчилгээний албан тушаалын үндсэн цалингийн хувийг тогтоох тухай А/33 дугаар тушаалыг үндэслэн 80 албан хаагчийн үндсэн цалинг 5-20 хувиар нэмэгдүүлэн тогтоож, 65,812.8 мянган төгрөгийн цалин хөлс илүү олгосон байна. Засгийн газраас албан хаагчдын албан тушаалын цалингийн доод хэмжээнд өөрчлөлт оруулах тогтоол гараагүй байхад байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн албан тушаалын цалингийн хэмжээг нэмэгдүүлэн тогтоосныг Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд анхаарах;

2. Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтны ажил үүргийг хавсран гүйцэтгэх тухай" А/214 дүгээр тушаалаар 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн аймаг, хотын Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга нарт Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг албан тушаалын цалингийн 40 хувиар тооцож олгох тушаалын дагуу Увс аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн даргад ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэлд 987.2 мянган төгрөг олгосон байна. Батлагдсан бүтэц, орон тоонд байхгүй албан тушаалыг хавсран гүйцэтгүүлж, нэмэгдэл олгож байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэгт "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 16.5.3 дахь зүйлд "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцаанд энэ хуулийг мөрдөх ба бусад хуульд өөрөөр заасан бол энэ хуульд заасныг дагаж мөрдөнө", 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3 дахь заалтад "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасантай нийцэхгүй байгааг Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,334.6 мянган төгрөгийн 2 алдаа илэрснийг залрууллаа.

Залруулсан алдаа:

1. Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд даатгуулагчийн кодын зөрүүнээс үүссэн 800.5 мянган төгрөгийн авлагыг тусгаагүй орхигдуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4 дэх заалтад "үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2 дэх заалтад "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.5 дахь заалтад "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй, Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул залруулга хийлгэлээ.

2. Сахилгын шийтгэлтэй 1 албан хаагчид 538.8 мянган төгрөгийн улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.5 дахь заалтад "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8 дахь хэсэгт "Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно", Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5

дугаар тогтоолын 2.7-д “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй” гэж заасантай нийцэхгүй, Хэмжилт батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул авлагаар тусгуулж залруулга хийлгэлээ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаа-гүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд даатгуулагчийн кодын зөрүүнээс үүссэн 800,485.0 төгрөгийн авлагыг тусгаагүй.	1	800.5	1	800.5			1	800.5				
Сахилгын шийтгэлтэй 1 албан хаагчид 538,800.0 төгрөгийн улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон.	1	538.8	1	538.8			1	538.8				
Дүн	2	1,339.3	2	1,339.3			2	1,339.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Байхгүй												
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Байхгүй								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Байхгүй								
Дүн								
Нийт дүн								

АУДИТЫН ТАЙЛАН

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



/М.БАТСУУРЬ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Т.АРИУНСАЙХАН/

2026.02.09